

**“ЛИМИТЭД ЭКО ПРОТЕКТ” ХХК  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА**



**УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 21-Р ХОРООНД  
БАЙРЛАХ, “ПЕТРОЛАЙН” ХХК-Н ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ  
АГУУЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

*Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 7-р хороо 11-р хороолол  
Их тойруу 82, Одкон холдинг 309а тоот  
Утас: 99296506, 90049995*

**2024 ОН**



## АГУУЛГА

<b>1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	4
1.1 Төслийн хүчин чадал.....	5
1.2 Төслийн талбайн өнөөгийн байдал.....	6
<b>2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b> .....	11
2.1 Уур амьсгал.....	11
2.2 Геологийн тогтоц ба геоморфологи.....	11
2.3 Гадаргын ус.....	12
2.4 Хөрсөн бүрхэвч.....	13
2.5 Ургамлан бүрхэвч.....	13
2.6 Амьтны аймаг.....	14
2.7 Нийгэм эдийн засаг.....	15
2.7.1 Хөдөлмөр эрхлэлт.....	15
2.7.2 Эрүүл мэнд.....	15
2.7.3 Дүүргийн төсөв.....	15
2.7.4 Аж үйлдвэр.....	15
<b>3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b> .....	16
3.1 Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	18
3.2 Усны нөөц, чанарт гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж.....	18
3.3 Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	18
3.4 Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	19
3.5 Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	19
3.6 Хүний эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны үед үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ.....	19
3.7 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ.....	20
3.8 Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөмж.....	20
<b>4.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ</b> .....	21
<b>5.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	22
<b>6.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	26
<b>7.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	26
<b>8.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	27
<b>9.ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	28
<b>10.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР</b> .....	29
<b>11.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	29



<b>12.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....</b>	<b>30</b>
--	-----------

### ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн товч танилцуулга.....	4
Хүснэгт 2.Төсөлд ашиглагдах хүчин чадлын мэдээлэл.....	5
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ.....	16
Хүснэгт 4.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн дүн .....	21
Хүснэгт 5. Төслийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө .....	22
Хүснэгт 6.Төслийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	26
Хүснэгт 7.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	26
Хүснэгт 8. Түүх соёл өвийг хамгаалах төлөвлөгөө .....	27
Хүснэгт 9. Төслийн хог хаягдлын төлөвлөгөө.....	28
Хүснэгт 10. Төслийн орчны хяналт шинжилгээ хийх төлөвлөгөө .....	29
Хүснэгт 11. Төслийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	29
Хүснэгт 12. Төслийн нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	30

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.Төслийн байршлын зураг .....	5
Зураг 2. агуулахын гадна талбай, орц, гарцын хаалга .....	7
Зураг 3. Газрын тосны агуулахын босоо сав.....	8
Зураг 4. Вагонцистернээс шатахуун ачих буулгах байгууламж.....	9
Зураг 5. Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын зураг төсөл .....	10
Зураг 6. Төслийн талбайн усны сав газрын байрши .....	12
Зураг 7. Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн хэв шинж.....	13
Зураг 8. Төлийн талбайн Ургамлан нөмрөгийн хэв шинж .....	14



## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн талбай нь Сонгинохайрхан дүүргийн 21-р хороонд байрлах, “Петролайн” ХХК-н Газрын тосны агуулах төсөл нь Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/105 тоот захирамжаар Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэрт, 361-ын гарам /18410/ бүсчлэлд 1802625964 нэгж талбарын дугаартай "Шатах тослох материал түгээгүүрийн газар, агуулах, шатахуун түгээх станц" зориулалтаар олгосон 19999.0 м<sup>2</sup> газрыг эзэмшсэн.


“Газрын тосны агуулах” нь босоо цилиндр ил резервуартай нийт савны хэмжээ нь 10000 (V=2000м<sup>3</sup>х5шир,) багтаамжтай 5 ширхэг сав, барилгажих талбай нь 333.6м<sup>2</sup>, агуулахын насос станц, 6 вагон буулгах эстакад, хос төмөр замаар вагон цистерн хүлээн авах вагон эстакад, босоо ган нөөцлүүр саванд шахах 5 ширхэг насос, 4 төрлийн шатахууныг нэгэн зэрэг автоцистернд ачих насос зэрэг шатахууны технологийн үндсэн байгууламжтай. Мөн 1 гүний худагтай, конторын барилга, харуулын байр, V=500 м<sup>3</sup> усан сан, 14.4 м<sup>2</sup> хэмжээтэй дээж хадгалах байр зэрэг байгууламжуудтай байна.

Газрын тосны агуулах төсөл нь:

- *Импортлох*
- *Хадгалалт-Агуулахад хүлээн авч хадгалах бөөний борлуулалт,*
- *Агуулахаас Шатахуун түгээх станцируу тээвэрлэх,*
- *Жижиглэн борлуулт, түгээлт хийх*
- *Бөөний борлуулалт гэсэн дээрх ажлыг чиг үүргийг баримтлан ажиллана.*

*Хүснэгт 1. Төслийн товч танилцуулга*

<b>Төслийн нэр:</b>	Газрын тосны агуулах
<b>Төсөл хэрэгжүүлэгч:</b>	“Петролайн” ХХК
<b>Төслийн байршил:</b>	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо, Рашаант хаягт байрлана.
<b>Төслийн зорилго:</b>	Одоогийн нөхцөлд нефть импортлогч томоохон аж ахуй нэгж компаниудаас бүтээгдэхүүний хангалтыг хийж байгаа бөгөөд 2024 онд багтааж бүтээгдэхүүн хадгалах агуулахыг ашиглалтанд оруулна.
<b>Регистрийн дугаар:</b>	5604907
<b>Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:</b>	УБ, ЧД, 14-р хороо, хайлааст-3, 12 тоот
<b>Утас:</b>	88102555



*Зураг 1.Төслийн байршлын зураг*

### 1.1 Төслийн хүчин чадал

*Хүснэгт 2.Төсөлд ашиглагдах хүчин чадлын мэдээлэл*

№	Үзүүлэлт	Тоо ширхэг	Тайлбар
1.	Багтаамж	10000 м3	2000 м3 5 ширхэг сав
2.	Борлуулах бүтээгдэхүүний төрөл	1,2-р сав ДТ, 3-р сав Евро ДТ, 4-р сав А-95 бензин 5-р сав Аи-92 бензин	Бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй.
3.	Түгээгүүрийн тоо	Хагас автомат ачих төхөөрөмж	Галын цахилгаан дохиоллоор тоноглогдсон.
4.	Гэрэлтүүлэгтэй саравч	1	Талбайн замын орц гарц, саравчны гэрэлтүүлэг стандартын дагуу хийнэ.
5.	Халаалт	Цахилгаан	Агуулахын цахилгаан хангамж нь төвлөрсөн эрчим хүчний системтэй.
6.	Операторын барилга	102,11 м2	Эрхлэгчийн өрөө, түгээгчийн өрөө, тос борлуулах өрөөнөөс бүрдэнэ. Хаягжилт, гэрэлтүүлэг сайтай, өдөр, шөнө хэдийд ч харагдана.
7.	Насос станцын байр	8x14 143,5м2	Технологийн дамжуулах хоолой, савласан бүтээгдэхүүний агуулах аянганаас хамгаалах байгууламж статик цахилгаан цэнэгжилтээс хамгаалах байгууламж, лаборатори байна.

8.	Ослын сав 10м <sup>3</sup>	2	Газрын тосны бүтээгдэхүүнд тэсвэртэй материалаар шатах тослогооны материалыг хадгалах зориулалтаар үйлдвэрлэсэн болон барьсан нэрлэсэн багтаамж бүхий сав.
9.	Автомашинны хөдөлгөөний зам талбай	2050,2 м2	Галын авто машин орж, гарах зориулалтын 2-оос доошгүй гарцтай.
10.	Явган хүний зам талбайн замын хашлага	1131,5 м2	Галын хөдөлгөөнт техник хэрэгсэл оруулах зориулалтын орцуудыг төлөвлөсөн эсэх.
11.	Үнэ сурталчилгааны самбар	3ш	Галын хөдөлгөөнт техник хэрэгсэл оруулах зориулалтын орцуудыг төлөвлөсөн эсэх.
12.	Галын багажны самбар	5 ш	Галын анхан шатны багаж хэрэгслээр нормын дагуу бүрэн хангана
13.	Аянга хамгаалагч	2 ш	Аянга болон цахилгаан статик цэнэгээс хамгаална.
14.	Цахилгаан	КТПН250/10 кВ	Агуулахын цахилгаан хангамж нь “Цахилгаан байгууламжийн дүрэм” БД-43-101-03 ба БНБД 21-03-04 дүүрмийн дагуу төлөвлөсөн.

### 1.2 Төслийн талбайн өнөөгийн байдал





*Зураг 2. агуулахын гадна талбай, орц, гарцын хаалга*

Шатахуун нөөцлөх савыг MNS5746:2007 стандартын дагуу багтаамж бүтээгдэхүүний нэр төрлөөс хамааруулан “Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, Галын аюулгүй норм дүрэм” БНБД 21-03-04-д заасны дагуу байрлуулна.

**Зам талбай:** Газрын тосны бүтээгдэхүүний агуулахыг ерөнхий төлөвлөгөөний дагуу, Агуулахын зам талбайд бусад зам талбайд ус орохоос хамгаалагдсан байхаар орсон хур тунадасны ус тогтоол үүсэхгүй шатахууны сав, худаг, барилга байгууламж, тусгай талбайд орохгүйгээр тооцож төлөвлөсөн.

**Цэнэглэх талбай:** Агуулахад шатахуун авч буй тээврийн хэрэгсэл зогсоход зориулсан

цэнэглэх талбайн шатахууныг хөрсөнд нэвчүүлэхгүй байх, асгарсан шатахуунд тэсвэртэй байхаар өндөр чанарын бетоноор цементжүүлсэн.

**Орлогын талбай /зогсоол/:** Хөрсөнд шатахуун нэвчүүлэхгүй байх зорилгоор автоцистерн зогсох бетон талбайг төлөвлөв. Хэмжилт хийх, ачааг бүрэн буулгах зориулалтаар талбайг налуугүй тэгш байхаар төлөвлөсөн.

**Технологийн хоолой:** Агуулахын технологийн хоолойг ган гэрт газар дор угсрахаар зураг төсөлд тусгав. Буулгах технологийн хоолойн налуу сав уруу чиглэсэн байх ба сорох технологийн хоолой налуу технологийн худаг руу чиглэсэн байна.

**Агааржуулалтын хоолой:** Шатахууны төрөл тус бүрт амьсгалах клапан төлөвлөв.

**Үнэртүүлэх хоолой:** Шатахууны сав тус бүрт гэмтэл гарч шатахуун хөрсөнд нэвчсэн нөхцөлд мэдрэх зорилгоор төлөвлөв.


**Шатахуун түгээгүүр:** Агуулахад 1 төрлийн бүтээгдэхүүний 2 хошуутай 1 ширхэг түгээгүүр суурилуулсан.

**Автоцистернээс буулгах төхөөрөмж:** Шатахуун тээвэрлэн ирсэн автоцистернээс шатахууныг саванд хүлээн авахад зориулагдсан буулгах төхөөрөмжийг автоцистерний талбайн дэргэд буулгах худганд байрлуулахаар төлөвлөв.

**Аянга зайлуулагч:** Агуулахын барилга байгууламжийг аянганаас хамгаалах зорилгоор 4 ш аянга зайлуулагч газардуулгатай.

**Шатахууныг саванд хадгалах**– Савны дүүргэлтийн дээд хязгаар нь савны паспортад тусгайлан заагаагүй тохиолдолд бодит багтаамжийн 95%-аас хэтрэх ёсгүй. Ашиглалтын ердийн нөхцөлд сав бүрэн битүүмжлэгдсэн, агаарын солилцоо зөвхөн амьсгалах клапангаар дамжин явагдах ёстой. Хадгалалтын үед саванд байгаа шатахууны түвшинг сүмбэнметрээр хэмжилт хийнэ. Саван дахь бүтээгдэхүүнийг дээжийг хэмжих люкээр зөөврийн дээж авагчаар авна. Авсан дээжиндээ шатахууны хувийн жин, температурыг зөөврийн багажаар хэмжих аргаар тодорхойлно.

Шатахууны нөөцлөх сав тус бүр нь үйлчилгээний люк, амьсгалах хоолой, хэмжих люк, үл буцаах клапан, шатахууны орлого, зарлагын хоолойгоор тоноглоно.



Зураг 3. Газрын тосны агуулахын босоо сав

### **Шатахууныг төмөр замаас хүлээн авах**

Төмөр замаар ирсэн ачааны баримт бичгийг шалгана. Шалгахдаа тухайн нефть бүтээгдэхүүний ангилал, хаяг, ачигдсан хугацаа, үйлдлийн алдаа, чанарын паспорт, торхны гэрчилгээ, баталгааны хугацааг нарийвчлан шалгана. Эдгээр шаардлагуудыг хангасан тохиолдолд хэмжилт хийнэ. Хэмжилтүүдийг стандартын дагуу хадгалах савыг шалгаж



шатах тослох материалыг тооцоолон орлого авна. Шатах тослох материалын хөөрөлт, суултын эзэлэхүүнийг тодорхойлно. Хэмжилт тооцоололтыг үндэслэн шатахуун илүү, дутуу тээвэрлэгдэн ирснийг шалгаж дуусаад тээвэрлэгч жолоочоор хянуулж, баталгаажуулна. Эцэст нь журмын дагуу хэвийн хорогдлыг тооцно.



Зураг 4. Вагонцистернээс шатахуун ачих буулгах байгууламж

Тус нефтийн бүтээгдэхүүний агуулах руу төмөр замын Аршаант өртөөнөөс Трансгайд Терминал ХХК-ны салбар замын 24-р үенээс сум №20-оор эхлэнэ.

Шатахуун тээвэрлэж ирсэн вагонцистерныг 510.54 метрийн урттай төмөр замын буулгах эстакадын 1 талаар тус бүр 6 хүртэлх тоогоор зогсоож, вагонцистерны хүйснээс битүүмжлэн буулгах таваг, ДУ250 коллектор бүхий буулгах байгууламж, ДУ250, ДУ200 мм-ийн голчтой дамжуулах шугам хоолой бусад дагалдах тоног төхөөрөмжүүд бүхий насос станцын тусламжтайгаар шатахууныг сорж, босоо ган савнуудруу шахаж нөөцөлдөг. Вагонцистернээс шатахуун буулгах байгууламж нь 4 төрлийн шатахууныг нэгэн зэрэг буулгах хүчин чадалтай бөгөөд төрөл тус бүрд зориулагдсан буулгах коллектор, шугам хоолой, насостой байна.



Зураг 5. Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын зураг төсөл

### 2.3. Дэд бүтэц

**Цахилгаан хангамж:** Агуулахын цахилгаан хангамж нь “Цахилгаан байгууламжийн дүрэм” БД-43-101-03 ба БНБД 21-03-04 дүүрмийн дагуу төлөвлөсөн.

**Дулаан хангамж:** Операторын байр, лабораторийн өрөө нийт 102 м<sup>2</sup> талбайтай ба автомат тохируулгатай цахилгаан халаагуураар дулаанаа шийднэ.

**Өрөмдмөл худгийн техникийн паспорт /Худаг-1/**

Цооногийн гүн: 70 м

Цооногийн ундарга: 2л/сек

Усны тогтсон түвшин: 45м

Ус өргөгч яндангийн диаметр: 32мм

Насосны штангийн диаметр: 32мм, урт 62м



## 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 2.1 Уур амьсгал

Уг төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 5-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын нутаг дэвсгэрийн гадаргуугийн өвөрмөц нөхцөл бүс нутгийн уур амьсгал бүрэлдэн тогтох нэгэн хүчин зүйл болдог. Өөрөөр хэлбэл Хан Хэнтийн нурууны их уулс нь Монгол орны төрдийгүй Төв Азийн уур амьсгал бүрэлдэхэд Сибирээс их говь руу өөрөөр хэлбэл уртгагийн дагуу түрж тогтсон байна. Хан Хэнтийн нурууны байгалийн чиглэлийн судалгаа, уур амьсгалын ерөнхий тодорхойлолт хийгдсэн. Гэвч нарийвчилсан судалгаа хомс байна. Харин Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газар байгуулагдсанаас хойшхи хугацаанд судалгаа өргөжиж байгаль орчин зүйн ажиглалтыг нилээд өргөн хүрээтэй, байгаль хамгаалагчдын нэгэн ажил болгож байгаа нь судалгааны суурь болж байна.

Хан Хэнтийн нурууг тойрон байгуулсан цаг уурын станц, харуулын олон жилийн баялаг мэдээлэл, ялангуяа Тэрэлж, Мөнгөнморьт, Хүрэлтогоот зэрэг станцуудын цаг уурын мэдээ сэлтийг хэрэглэв. Горхи - Тэрэлжийн байгалийн цогцолборт газар нь эх газрын эрс тэс уур амьсгалтай. Уур амьсгалын үзүүлэлтүүд нэг тэгш хэмийн хуваарилалттай. Жилийн 4 улирлын өнгө алаглан ээлжлэн солигдож тод илэрдэг. Хаврын дулааралт намрын сэрүүсэлтийн явц ижилхэн зун нь сэрүүн чийглэг, өвөл нь хүйтэн чийглэг, уур амьсгалын үзүүлэлт нь хэм тэнцүү хуваарилалттай. Монгол орны бусад нутгаас хамгийн их хур тунадастай, чийглэг, сэрүүн өвөл нь цасархаг харьцангуй дулаавтар тунгалаг цэнгэг агаартай. Хавар нь хуурайвтар, хахир хахирлаг, намар нь өгөөж баян сэрүүн сэрүүвтэр, үе үе хөрөлтийн буюу цацрагийн манан, хүдэн татаж байдаг.

### 2.2 Геологийн тогтоц ба геоморфологи

Улаанбаатар хот орчмын геологийн тогтоц нь монгол орны геологийн тектоникийн ангиллын Хэнтийн хотгорт хамаарагдана. Тухайн нутаг дэвсгэрт доод карбон, доод цэрд, неоген, дөрөвдөгчийн хурдас, доод мезойн бялхмал чулуулгийн бүрдэл илүүтэй зонхилно. Судалгааны талбай нь геоморфологийн хэв шинжийн хувьд, уулын бэл хормойн хурдас чулуулгийн зөөгдөл-хуримтлалын гадаргуугийн хэсэгт хамаарагдана.


Байгал нуурын сав нутаг Евроази тивийн төвд байрладаг явдал байгалийн үндсэн шинж, өвөрмөц байдлыг тодорхойлдог. Эртний газарзүй, геологийн тогтоцын онцлог нь газрын гадаргын төлөв байдлыг нөхцөлдүүлэх бөгөөд хожуу мезозой ба кайнозойн эриний турш үргэлжилсэн тектоникийн босоо хөдөлгөөнүүд уул, хотгор хосолсон гадаргын төрхийг үндсэнд нь бүрдүүлдэг. Байгал нуурын сав газрын уулзүйн тогтоц тун нарийн. Эндэхийн хотгор гүдгэр бүхэлдээ плиоцен-дөрөвдөгчийн нэгдмэл үүсэлтэй бөгөөд энэ цаг хугацаанд ерөнхий өндөрлөгийн дэвсгэр дээр зарим блокууд доошоо нилээд суулт өгсөнөөс болоод хоёр хэвшинжийн хотгор-ховдолууд үүсэхэд хүрчээ. Нэгдэх (Байгалийн) хэвшинж нь эх газрын дотоод дахь байгалийн рифтийн (хадан цохионы) бүс дэх техтоник үйл ажиллагааны идэвхжилтэй холбоотой. Энд шинэхэн тектоникийн босоо хөдөлгөөний агууриг болон сэвсгэр хурдасны зузаан хамгийн их хэмжээтэй байна. Энэ районд дэлхийн царцдасын хөдлөл одоо хүртэл нилээд ажиглагдаж газар чичирхийллийн өндөр идэвхжилтэй тул газар хөдлөлт (байн, байн заримдаа хүчтэй) болдог. Хоёр дахь (Өвөр байгалийн) хэвшинж нь Сэлэнгэ мөрний сав газарт өргөн тархсан уулс хоорондын уудам хөндийнүүд бөгөөд

тэдгээрийн үүсэл мезозойн эриний сэргээгдсэн хотгорууд дээрх гүний тектоникийн залуу эвдрэлүүдтэй холбоотой.

### 2.3 Гадаргын ус

Усзүйн хувьд Хойд мөсөн далайн ай савын Туул голын ай савд багтах бөгөөд олон жилийн дундаж урсац нь 100м-ээс илүү бүс нутагт хамаарна.

Туул гол нь эхэндээ (эхээс 170 орчим км) олон тооны гол горхи, булаг ихтэй бөгөөд Хэнтийн нурууны салбар уулсаас эх авсан Галтгай, Хийд, Хаг, Зүүн баян, Тэрэлж, Улиастай, Сэлбэ зэрэг голууд цутгах ба харин голын уртын дагуугийн үлдэх ихэнхи доод хэсэгт Түргэн, Харбух, Тосон зэрэг цөөн тооны жижиг гол горхиуд цутгана. Голын ус хурах талбай 49900 км<sup>2</sup>, урт нь 874 км, ус хагалбарын шугамын урт 2055,6 км, ус хурах талбайн дундаж өндөр 1474 м, голдрилиын ерөнхий хэвгий 13% юм. Туул голын савд гол, горхины сүлжээний нягтшил дунджаар 0.39 км/км<sup>2</sup>, хэсэглэн авч үзвэл голын эх Гачуурт хүртэл 0.54 км/км<sup>2</sup>, Гачууртаас Лүн 0.1 км/км<sup>2</sup>, Лүнгээс Заамарын алтны бүс Орхон Туулын бэлчир хүртэл 0.05 км/км<sup>2</sup> байна. Туул голын өргөн нь үергүй үед 35-75 м, гүн нь 0.8-3.5 м, урсгалын хурд 0,50-1.50 м/с, эргийн өндөр 0,5-2,5 м байдаг./Эх сурвалж: Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Усны нэгдсэн менежмент, Туул голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан судалгааны эмхэтгэл, УБ, 2012/ Туул голын ус хэмжилтийн Улаанбаатар харуулын урсацын ажиглалтын мэдээнд (1945- 2008) тулгуурлан жил бүрийн зарцуулгаар Туул голын тэжээлийг тогтоох урсацын гидрографын задлан ялгалт хийсэн дүнгээс үзвэл олон жилийн дунджаар хайлсан цас, мөсний ус 10.2%-ийг, газар доорх ус хөрсний усны тэжээл 17.65%, хур борооны ус 72.15% тус тус эзэлж байна.




Зураг 6. Төслийн талбайн усны сав газрын байрши

## 2.4 Хөрсөн бүрхэвч

Хөрс-газарзүйн мужлалтаар Хангайн их мужийн хагас чийглэг өндөршлийн бүсчлэл бүхий Хэнтийн өмнөд тойрог багтана. Нутгийн хойд захаар Ширэгт тайгын гүндээ цэвдэгтэй хөрс, хотын хойд захын уулсаар уулын нунтаг карбонатлаг хар хүрэн хөрс, Туул голын хөндийгөөр нугат намгийн цэвдэгт хөрстэй. Богдхан уулын хад асга бүхий уулын тэгш оройд уулын нугын хөрс, түүнээс доош ой-тайгын хөрс, ой модгүй ар, өвөр хажуу болон өргөн амуудад хээрийн хөрс тархана. Ул хөрсний цэвдэг Улаанбаатар хотын дэвсгэрт толбо байдлаар тархсан.

Төслийн талбай нь Монгол орны хөрс газарзүйн мужлалаар Хангайн уур амьсгалын их мужийн хагас чийглэг өндөршлийн бүсчлэл болох Хэнтийн өмнөд тойрогт багтана. Энд хад асга бүхий уулын тэгш оройд уулын нугын хөрс, түүнээс доош ой тайгын хөрс, ой модгүй ар өвөр хажуу болон өргөн амуудад нь хээрийн хөрс тархана. Төсөл хэрэгжиж буй Хан-Уул дүүрэгт аллювийн нугын сулавтар хөгжилтэй, аллювийн ширэгт, нугын хүрэн, уулын хар хүрэн, хар хүрэн хөрс тархсан. Эдгээрээс харахад төсөл хэрэгжиж буй орчинд нугын хүрэн хөрс зонхилно.




Зураг 7. Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн хэв шинж

## 2.5 Ургамлан бүрхэвч

Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойрог: Хэнтийн нурууны захын салбар уулсыг хамрах бөгөөд Хэнтийн тойргийг тал цагираг байдлаар хүрээлэн оршино. Хэнтийн нурууг тойрсон Онон, Улз, Туул, Хараа, Ерөөгийн хөндийн зурвас нутгийг хамаарна. Ургамлын аймгийн хувьд гол нь Дагуурын ойн ба уулын хээрийн төлөөлөгчдөөс, өмнөд захаар нь Монголын хээрийн төлөөлөгчдөөс бүрдэл болно.

Тус тойрогт нийт 1310 зүйл тархсан ба уулархаг хээрийн ургамал зонхилно. Зөвхөн энэ тойрогт тохиолдох 50 зүйл (Urgamal et al. 2016) ургамал тэмдэглэгджээ. Үүнд: Дагуур тооронцор (*Cerastium dahuricum*), Манжуур хус (*Betula mandschurica*), Дагуур гандбадраа (*Veronica dahurica*), Гмелиний шинэс (*Larix gmelinii*), Монгол хус (*Betula mongolica*), Хэвтээ биелэг (*Poa supina*), Хөхногоон даагансүүл (*Koeleria glauca*), Элдэвнавчит тарна (*Polygonum heterophylla*), Дагуур тооронцор (*Cerastium dahurium*), Шар лидэр (*Sophora flavescens*), Норвеги гичгэнэ (*Potentilla norvegica*), Хавтагнавчит хөхтолгой (*Eryngium planum*), Пенсилваны сараана (*Lilium pensylvanicum*), Хунчирхуу яргуй (*Pulsatilla astragalifolia*), Цагаан хошоон (*Melilotus albus*), Нугын хошоонгор (*Trifolium pratense*), Нугын шимтэглээ (*Geranium transbaicalicum*), Гмелений холтсонцэцэг (*Ranunculus gmelinii*), Нангиад хунчир (*Astragalus chinensis*), Дуулгачивт цахирам (*Orchis militaris*), Охоотын чөдөр өвс, Монньегийн халагацай (*Cnidium monnieri*), Дагуур дэгд (*Gentiana dahurica*), Борнуур багваахай (*Taraxacum bornuurensis*), Крыловын гандбадраа (*Veronica krylovii*), Сэлэнгийн шарилж (*Artemisia selengensis*) гэх мэт болно.



Зураг 8. Төлийн талбайн Ургамал нөмрөгийн хэв шинж

## 2.6 Амьтны аймаг

Дөрвөн уулын дунд орших байгалийн хэв шинж нь тус нутгийн унаган экосистем байсан бөгөөд энэ нь Улаанбаатар хот байгуулагдан аажмаар хөгжин тэлэхийн хирээр үржил шимт хөрсийг бүрэн түрж, хүний үйл ажиллагааны нөлөө удаан хугацаагаар ноёлж байгаагаас тус нутгийн унаган хөрс ургамлын экосистем бүрэн алдагдаж хүний үйл ажиллагаагаар бүрдсэн хайрга, элс, шорооноос тогтон буй болжээ.

Төслийн талбай нь төв суурин газар байрлах учир зэрлэг ан амьтан тохиолдох боломжгүй. Талбайд цөөн зүйл төв суурин амьдралтай шувууд хаа нэг тохиолдоно. Энд хон хэрээ, болжмор, тагтаа, шаазгай улаан хушуут жунгаа зэрэг цөөн зүйл жигүүртэн



ТОХИОЛДОНО.

## 2.7 Нийгэм эдийн засаг

### 2.7.1 Хөдөлмөр эрхлэлт

2023 оны 02-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 165 байгаагаас 79(47.9%) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 3(1.8%) нь магистр доктор, 76(46.1%) нь дипломын болон бакалаврын дээд, 14(8.5%) нь тусгай мэргэжлийн дунд, 16(9.7%) нь техникийн болон мэргэжлийн, 46(27.9%) нь бүрэн дунд, 3(1.8%) нь суурь, 4(2.4%) нь бага боловсролтой, 3(1.8%) нь боловсролгүй иргэд байна.

Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 23(13.9%) нь 15-24 насны, 69(41.8%) нь 25-34 насны, 44(26.7%) нь 35-44 насны, 22(13.3%) нь 45-54 насны, 6(3.7%) нь 55-59 насны, 1(0.6%) нь 60 дээш насны иргэд байна. Бүртгэлтэй ажил хайгч (2023.01 сарын байдлаар) иргэдээс 54 хүн ажилд зуучлагдан орсноос 10(18.5%) нь 15-24 насныхан, 18(33.3%) нь 25-34 насныхан, 17(31.5%) нь 35-44 насныхан, 7(13.0%) нь 45-54 насныхан, 2(3.7%) нь 55-59 насны иргэд байна.

### 2.7.2 Эрүүл мэнд

2022 оны эхний 2 сард 1000 эхээс 1004 хүүхэд мэндэлсэн байна. Өнгөрсөн оны мөн үед 585 эхээс 582 хүүхэд мэндэлж байжээ. Тайлант хугацаанд 0-1 насны хүүхдийн эндэгдэл 11 гарсан нь өмнөх оны мөн үеээс 2(22.2%) – аар өссөн байна. 1-5 насны хүүхдийн эндэгдэл 2 гарсан байгаа нь өмнөх оны мөн үеээс 1(50.0%)-аар өссөн байна. Харин тайлант хугацаанд эхийн эндэгдэл гараагүй байна. Тайлант оны 1 сард 0-1 настай хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөнд 11 промилл ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үеээс 4.5(29.0%) буурсан байна.

### 2.7.3 Дүүргийн төсөв

Дүүргийн төсвийн нийт орлого 2023 оны 02 сард 9.5 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 7.0(42.2%) тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ. Төсвийн нийт орлогын 9.3(67.5%) тэрбум төгрөгөөр татварын орлого, 214.8(83.9%) сая төгрөгөөр татварын бус орлого бүрджээ. 2023 оны 02 сард татварын нийт орлогын 7.9(75.4%) тэрбум төгрөгөөр орлогын албан татвар, 198.5(25.2%) сая төгрөгөөр өмчийн татвар, 735.6(45.0%) сая төгрөгөөр газрын төлбөр, 428.2(51.0%) сая төгрөгөөр бусад татвар хураамжаас тус тус бүрдүүлсэн байна.

### 2.7.4 Аж үйлдвэр

Дүүргийн аж үйлдвэрийн газрууд 2023 оны эхний 2-р сард 172.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 211.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийжээ. Дүүргийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 127.1 (73.6%) тэрбум төгрөгийг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 45.5 (26.4%) тэрбум төгрөгийг хүнсний бус бүтээгдэхүүний үйлдвэрлэл эзэлж байна. Нийт хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 32.6 (25.7%) тэрбум төгрөгийг мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 32.0 (25.3%) тэрбум төгрөгийг сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 22.5 (17.7%) тэрбум төгрөгийг үр тарианы гурил, малын тэжээлийн үйлдвэрлэл, 11.5 (9%) тэрбум төгрөгийг ундаа үйлдвэрлэл, 28.3 (22.3%) тэрбум төгрөгийг хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл эзэлж байна.



### 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү бүлэгт төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд түүнд өртөх газрын гадарга агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, түүх соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тодорхой тусгана.

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагаатай холбогдох хууль, дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж ажиллахаас гадна онцлог шинж чанар, хор аюул, хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт талаар ажиллагсад мэдлэг олгож, болзошгүй сөрөг нөлөөлөл, осол эрсдлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд авах арга хэмжээний талаар дотоод дүрэм, журам боловсруулан мөрдөж ажиллах нь зүйтэй.

Төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээнээс харахад байгаль орчинд төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх гол сөрөг нөлөөллийг тодорхойлбол:

- Нефтийн бүтээгдэхүүн хадгалах агуулахын авто зам тавихтай холбоотой карьер, ухсан нүх, хонхорт тогтсон тогтоол усанд элдэв шавж өсч үржих, ингэснээр бохирдлын эх үүсвэр бий болох
- Автомашин, тээврийн хэрэгслийн дуу чимээ нэмэгдсэнээр ан амьтан дайжих, байршил тархалт нь өөрчлөгдөх, амьдрах орон зай нь хумигдах
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэх, үүнтэй уялдан хөрс дагтарших, эвдрэх, ургамал нөмрөг алдралд орох, улмаар хөрсний үржил шимт хэсэг устаж алга болох, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөх
- Хог хаягдлаа замбараагүй хаявал гадаргын ус болон хөрс, ургамал бохирдох
- Хийн хаягдал агаар орчин бохирдуулах
- Түүхий эдийг тээвэрлэх явцад технологи үйл явцаа зөв зохион байгуулахгүй бол байгальд нөлөөлөх магадлалтай байна.

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

№	Төслийн гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ
1.	Энгийн хог хаягдлаас үүдэлтэй орчны бохирдол үүсэх. Хог хаягдал ил задгай хаях, хог хаягдлын цэгт ариутгал халдваргүйтгэл хийхгүй байх, тогтмол хугацаанд зайлуулаагүйгээс элдэв шавьж үржих, халдварт өвчний эх үүсгэвэр болох	<ul style="list-style-type: none"> <li>✓ Зориулалтын тусгай цэг тохижуулах</li> <li>✓ Тогтсон хугацааны давтамжтай, тогтмол ачин зайлуулах</li> <li>✓ Хогийн цэгт байнга ариутгал халдваргүйжүүлэлт хийх</li> <li>✓ Зориулалтын бус газарт шатааж агаар орчин бохирдуулахгүй байх</li> <li>✓ Ил задгай хаяж орчныг бохирдуулахгүй байх</li> <li>✓ Эх үүсвэр дээр нь ангилан ялгах</li> <li>✓ Дахиварыг хэрэглэгч байгууллагад дахин боловсруулахаар шилжүүлэх</li> </ul>
2.	Тээврийн хөдөлгөөн ихсэх, хөрс, ургамал талхагдах	<ul style="list-style-type: none"> <li>✓ Орчны хөрсийг тогтмол цэвэрлэх, нөхөн сэргээх, зүлэгжүүлэх, мод тарих,</li> <li>✓ Тогтоосон замыг засаж сайжруулах, тэмлэглэгээ хийх, явган хүний зорчих замыг хийж тохижуулж, асфальтаар хучих зэрэг арга хэмжээ авах</li> </ul>





3.	Газрын тосны бүтээгдэхүүнээр агаар ус, хөрс бохирдох	<ul style="list-style-type: none"><li>✓ Агуулахын агааржуулалтын ажиллагааг байнга хянаж хэвийн ажиллагаатай байлгах, агааржуулалтын систем мембран шүүлтүүртэй байх, тогтмол хугацаанд солидог байх.</li><li>✓ Хадгалах, тээвэрлэх, худалдаалах, ашиглах үеийн аюулгүй ажиллагааны заавар боловсруулан мөрдөж ажиллах</li><li>✓ Агуулахыг хариуцсан мэргэжлийн хүн ажиллуулах</li><li>✓ Гадаргын болон газрын доорх усанд алдахгүй байх</li></ul>
4.	Газрын тосны бүтээгдэхүүнд өртөх, хүн амьтанд хортой аюултай нөлөө үзүүлэх	<ul style="list-style-type: none"><li>✓ Химийн ШУ, Газрын тосны бүтээгдэхүүний талаар суралцсан мэргэжлийн хүн ажиллуулах</li><li>✓ Бодисын хор аюул, нөлөөллийн талаарх мэдээ мэдээлэл өгөх сургалт байнга зохион байгуулах</li><li>✓ Байгальд ил задгай хаяхгүй байх</li><li>✓ Бодистой ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр бүр өгөх</li><li>✓ Зааварчилгаа, дүрэм журмыг мөрдөн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих</li></ul>
5.	Түлшээр бохирдсон хортой, аюултай хог хаягдал гарах	<ul style="list-style-type: none"><li>✓ Аюултай хог хаягдал үүсгэгчийн код авах</li><li>✓ Хог хаягдлын тухай хуулийг мөрдөж ажиллах</li><li>✓ Аюултай хог хаягдал цуглуулж түр хадгалах тусгай цэг, хадгалах агуулах бий болгож хяналттай байлгах</li><li>✓ Газрын тосны бүтээгдэхүүнээр бохирдсон материал, эд зүйл, хугацаа дууссан бодис урвалж зэрэг аюултай хог хаягдлыг ангилан хадгалах</li><li>✓ Бохирдсон бүх зүйлийг тусгайлсан хогийн цэгт түр хадгалах Аюултай хог хаягдлыг хуульд заасны дагуу хэмжээнээс хамааран 90 хоног хүртэл хадгалах</li><li>✓ Эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй байгууллагатай эрх шилжүүлэх гэрээ хийх, дагалдах маягт бүртгэлийг хөтлөж бүртгэх</li><li>✓ Эрх шилжүүлэхдээ дагалдах бичиг баримтыг бүрдүүлж ажиллах</li><li>✓ Аюултай хог хаягдлын тайланг жил бүрийн 11 сард гаргаж харьяа дүүргийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст албан тоотор хандан хүргүүлэх</li></ul> <p>Дээрх үйл ажиллагаануудын хууль эрх зүйн үндсийг доор тусгав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>✓ Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/</li><li>✓ Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам /2018, 116-р тогтоол 1 дүгээр хавсралт/</li></ul>
6.	Газрын тосны бүтээгдэхүүний тээвэрлэлт, түүнтэй холбоотой аюул эрсдэл гарах /гэнэтийн осол аваарь, техникийн бүрэн бус байдал, жолоочийн хариуцлагагүй байдал/	<ul style="list-style-type: none"><li>✓ Байгууллагын “Химийн ослоос урьчилан сэргийлэх, ослын үед ажиллах төлөвлөгөө”-нд тээвэрлэлтийн үйл ажиллагааг сайтар нарийн тусгаж, Газрын тосны бүтээгдэхүүний тээвэрлэлтийн маршрутаа батлан хавсаргах</li><li>✓ Тус төлөвлөгөөнд “Бодисын асгаралт бага үед авах арга хэмжээ, саармагжуулах арга”, “Бодисын асгаралт их үед авах арга хэмжээ, саармагжуулах арга”-ыг тус тус нарийвчлан тусгаж өгөх, харьяа дүүргийн ОБГ-аар шинэчлэн хянуулж батлуулах.</li><li>✓ Тогтоосон маршрутаас ангид тээвэр хийхийг хатуу хориглох</li><li>✓ MNS 4978:2017 Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлагыг хангасан тээврийн хэрэгслэлээр тээвэрлэлтийг хийх</li><li>✓ Аюултай ачаа тээвэрлэх тусгай зөвшөөрөл авах</li><li>✓ Дадлага туршлагатай тээврийн ангилалд нийцсэн жолоочийг аюул эрсдэлээс сэргийлэх сургалтад хамруулсны дараа тээвэрлэх тээвэрт явуулах</li><li>✓ Өөрсдөө тээвэр хийх боломжгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл бүхий тээвэрлэлтийн компаниар тээвэрлэлтийг</li></ul>



гүйцэтгүүлэх.

### 3.1 Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

- Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах явцад тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэл болон хадгалах шаардлагын дагуу хадгалаагүй тохиолдолд агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.
- Хадгалалтын горим хангахгүй ууршиж дотоод даралт нэмэгдэх, дулаанд тогтворгүй бүтээгдэхүүний шинж чанар өөрчлөгдөж, тэсэрч дэлбэрэх, галын аюул гарах, бүтээгдэхүүний чанар өөрчлөгдөх, асгарч алдагдах эрсдэлтэй.
- Тээвэрлэх машины тоног төхөөрөмж, ялангуяа дизель түлшээр ажилладаг хүнд даацын машин, техникийн хорт утаа ялгарах зэргээр агаарын чанарт сөргөөр нөлөөлнө
- Газрын тосны бүтээгдэхүүнийг тээвэрлэх шаардлагыг дагаж мөрдөөгүй, урвалд орох, галын аюул гарах зэргээр агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.

### 3.2 Усны нөөц, чанарт гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж

- Ахуйн хэрэглээний бохир ус нь гадаргын болон газрын доорх усны чанарт сөрөг нөлөөлөл үзүүлнэ.
- Хавар цас хайлах, зун намар эрчимжил ихтэй хур бороо орох үед замыг хөндлөн огтоолж буй сайр, судгуудад богино хугацаанд урсац үүсэж, үерлэж болзошгүй.
- Хур тунадас, ялангуяа эрчим ихтэй бороогоор сайр, судгууд үерлэн зам, ус зайлуулах байгууламжийг эвдлэх тохиолдол үүсэж болзошгүй.
- Агуулах руу явах шинээр байгуулах зам нь түүнийг хөндлөн байршиж байгаа сайр, судаг, жалгын үерийн усыг хааж хиймэл далан үүсгэнэ. Ингэснээр хур бороо ихтэй жил сайр судгийн татамд ус тогтон улмаар намагшилд үүсэж болзошгүй.
- Мөн хаврын цасны хайлсан ус сайр судгийн татам, хиймэл даланд шавар үүсгэж хаврын ядарч туйлдсан мал, амьтан шигдэх, зоогдох эрсдэлтэй.
- Замын ус өнгөрөөх гаргалгаа зэрэг нь салхи ба усны урсгалаар байнга зөөгдөх хагшаасаар дүүрч хур борооны болон уруйн үерийн үед бөглөрч зохиомол үер үүсгэж, зам болон ус өнгөрөөх байгууламжийг эвдэлж, сэтэлж, гуу жалга үүсгэн нурааж болзошгүй.

### 3.3 Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

- Агуулахын хашааны гадна, дотор явган хүний болон автозам тавихад ашиглагдах чулуу, шороо, цемент хийцийн үлдэгдлээр орчны хөрс бохирдоно. Мөн хөрсөнд эдгээр бохирдол нэвчих талтай.
- Хамгаалалтын сахиул айл, агуулахын байр талбай, машин техник, хүнд механизмуудын зогсоол зэрэг газарт хөрс ургамал талхлагдах, шатах тослох материал, хог хаягдлаар орчин, хөрс бохирдоно.
- Хөрс их хэмжээгээр эвдэрч, бүтэц шинж чанараа алдан ургамлан нөмрөгөө устгуулах ба улмаар хөрснөөс хийсэх шорооны хэмжээ ихсэж цөлжилтийн үйл явцыг түргэсгэх болно.
- Газрын тосны бүтээгдэхүүн тээвэрлэх /машин тоног төхөөрөмж, ялангуяа ил задгай тээвэрлэх, сав баглаа боодол нь эвдэрч гэмтсэн/ үед цас борооны усаар



угаагдан норж машины тэвш, газарт үлдэх зэргээр хөрсний чанарт сөргөөр нөлөөлнө.

- Газрын тосын бүтээгдэхүүний асгаралт нь хөрсний чанарт сөргөөр нөлөөлнө
- Агуулах барих ажилчдын байр, машин техник, хүнд механизмуудын зогсоол зэрэг газарт хөрс ургамал талхлагдах, шатах тослох материал, хог хаягдлаар орчин, хөрс бохирдоно.
- Бүтээгдэхүүнийг ачиж, буулгах үед аюулгүй ажилгааны дүрмийг баримтлаагүйн улмаас хөрсөн дээр асгарах, хөрсөн бүрхэвч бохирдох

### 3.4 Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

- Ургамлын бичил орчин өөрчлөгдсөнөөс нутгийн унаган ургамалшилтад өөрчлөлт орж, хогийн ургамлын төрөл зүйл ихсэх магадлалтай.
- Агуулахын үйл ажиллагаа, автомашины замын тоос зэрэг нь ойр орчмын агаарыг тоосжуулахаас гадна, ургамлын навч эрхтэнд шороон тоос цугларч ойр хавийн ургамлын цаашдын амьдралд сөрөг нөлөө үзүүлнэ.
- Ургамлын ургац ашиглалт явуулж буй хэсэгт бүрмөсөн устаж, зарим халцгай буюу талхагдаж орсон хэсэгт хогийн ургамал ялангуяа шарилж ихээр ургаж хүн амьтны амьсгалд тоосны аллерги үүсэх үндэстэй
- Ургамлын ургац ашиглалт явуулж буй хэсэгт бүрмөсөн устаж, зарим халцгай буюу талхагдаж орсон хэсэгт хогийн ургамал ялангуяа шарилж ихээр ургаж хүн амьтны амьсгалд тоосны аллерги үүсэх үндэстэй
- Машин техник хэрэгслийн түлш шаталтын дүнд үүссэн хорт хийд агуулагдаж буй NOx болон SOx тунадастай хамт юмуу хатуу тоос хэлбэрээр ургамлан бүрхэвч дээр бууж цааш хөрсөөр дамжин тархан ургамал, амьтанд сөргөөр нөлөөлөх.

### 3.5 Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

- Машин техникийн нөлөөгөөр тухайн орчин тархсан хөхтөн амьтад дайжих, шувууд үргэх зэрэг нөлөөлөлтэй.
- Агуулахын үйл ажиллагаа нь дуу шуугиан, тоос шорооны улмаас ихэнх хөхтөн амьтад дайжин үргэх зэргээр нөлөөлнө.
- Үйл ажиллагаанаас жижиг мэрэгч амьтдын хувьд дуу чимээ, тоос шороо сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай.
- Хүн, машин техникийн дуу чимээ, хөдөлгөөн, янз бүрийн таагүй үнэр, гэрэл эрс нэмэгдэж тухайн нутаг болон орчны бүс дэх амьтдын тайван байдал алдагдаж, дүрвэн зайлж байршил нутгаа өөрчилнө.
- Техникийн тос, шатахуун, янз бүрийн хаягдалд амьтад хордож үхэх, тэдгээрийг идсэн махчин амьтад хордоно.
- Цахилгааны болон холбооны шугамуудад шувуу гэмтэх, үхэх тохиолдол олширно.
- Шөнийн идэвхтэй шавж гэрэлд бөөгнөрч олноор шатаж үхнэ.
- Газрын тосны бүтээгдэхүүнийг тээвэрлэх, ажилчид ажилдаа явах үед замын хөдөлгөөн ба замын дундаж хурд зэргээс амьтад авто машинд дайрагдах эрсдэл нэмэгдэнэ.

### 3.6 Хүний эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны үед үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- Стандартын дагуу хадгалаагүй улмаас тэсэрч, дэлбэрэх, урвалд орох, галын аюул



гарснаар ажилчдын эрүүл мэнд болон агуулахын эд хогшил, байгаль орчинд сөрөг нөлөөллийг үзүүлнэ

- Түлшийг тээвэрлэн авчрахад хурд хэтрүүлэх, хөдөлмөр аюулгүй байдлын дүрмийг даган мөрдөж ажиллаагүйн улмаас осол аваар гарах, хүний амь нас эрсдэх эрсдэлтэй
- Хүний буруутай үйл ажиллагааны улмаас галын аюул гарах, осол аваар гарах, ХАБ дүрмийг даган мөрдөөгүй зэргээр хүний амь нас болон үйлдвэрийн эд хогшилд сөрөг нөлөөллийг үзүүлэх эрсдэлтэй
- Агуулахын ХАБ-ын дүрэм зорчих зэргээс үүдэн ажилчдын эрүүл мэнд аюулгүй байдалд эрсдэл учруулна.

### 3.7 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл (газар хөдлөлт, үер, хүчтэй салхи, хүчтэй шуурга) болоход гэмтэж бэртэхээс урьдчилан сэргийлж, ажиллагсдыг сургалтад хамруулж дадлагажуулах, эмнэлгийн анхны тусламжийн хайрцгийг талбайд байрлуулах.
- Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохыг хатуу хориглох.
- Ажиллагсад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах.
- Ажил олгогч нь ажилтнуудын ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах.

### 3.8 Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөмж

- Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь дам байдлаар хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болно. Иймд ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөл үүсэхээс сэргийлж агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг дагаж мөрдөх.
- Ажилтан бүр ажил олгогчийн баталсан жагсаалтын дагуу хөдөлмөрийн нөхцөл, ажил, үүргийн онцлог тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангагдаж, тэдгээрийг хэрэглэх үүрэгтэй.
- Ажлын байрны аюулгүй ажиллагааны нөхцөлд байнга хяналт тавьж, осол аюул гарсан тохиолдолд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангах, холбогдох сургалтыг явуулах.
- Ажлын байрны эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл болон тохижилтыг дээд зэргээр ханган, байнгын хяналт тавин ажиллах.
- Ажиллагсдыг ажилд ороход нь эмнэлгийн үзлэг хийлгэж, эрүүл мэндийн хувьд тэнцэх эсэхийг тодорхойлуулсан байх ба эрүүл мэндийн үзлэгт жилд 1 удаа хамруулахын зэрэгцээ эрүүлжүүлэх арга хэмжээ зохион байгуулах.



#### 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Газрын тосны бүтээгдэхүүний агуулах” төслийн БОМТ-г Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав. БОМТ-ний хүрээнд авч хэрэгжүүлэхэд 8.940.000 зарцуулахаар байна.

*Хүснэгт 4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн дүн*

№	Зардлын ангилал	2024 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж	1.600.000
2	Нөхөн сэргээлтийн зардал	2.875.000
3	Хог хаягдал	2.480.000
4	Удирдлага зохион байгуулалт	-
5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1.600.000
6	ОХШХ	385.0000
7	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хэлэлцүүлэх хуваарь	-
		Нийт дүн 8.940.000



## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Газрын тосны бүтээгдэхүүний агуулах” -ний төслийн Байгаль орчны ерөнхий үнэлгээний тогтоогдсон төслийн гол ба болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийн хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгалаа.

Хүснэгт 5. Төслийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө								
“Газрын тосны бүтээгдэхүүн агуулах тээвэрлэх үед шуугиан зөвшөөрөгдөх түвшнээс ихэснэ.	Тээвэрлэлт хийхдээ олон салаа зам гаргуулахгүйн тулд нэгдсэн нэг замаар явах нөхцөлийг хангах	Тогтоосон маршрутын дагуу түр зам хэрэглэх, тэмдэг тэмдэглэгээ	төг	150.000	4	600.000	2024 он	MNS 4597:2003 Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага
	Тоосжилт ихсэх үед чийгшүүлэх арга хэмжээг цаг агаарын улирлын байдлыг харгалзан авах	Тоосжилт их хэсэгт	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд		2024 он	Дизель хөдөлгүүртэй автомашин - Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009	
	Дагтаршаагүй замаар явах үедээ машин техникийн хурдыг хязгаарлах	Төслийн талбай	-	Үйл ажиллагааны хүрээнд		2024 он	Агаарын тухай" болон MNS 6063:2010 "Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ"	
	Тоосжилт их газруудад агаарын чанарт мониторинг хийх	Төслийн талбай	төг	Орчны хяналт шинжилгээний зардалд тооцов		2024 он		
	Машин техникийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, зориулалтын газар засвар үйлчилгээг тогтмол хийж	Шуугиан ихтэй техник, тоног төхөөрөмжүүд, түүнтэй харьцаж	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд		2024 он	MNS 6768 : 2019 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь	
	Шуугиан ихтэй тоног төхөөрөмжид ажиллаж буй хүмүүст хамгаалах хэрэгсэл олгож хэрэглүүлэх	ажилладаг ажиллагсад	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд		2024 он	шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээ, ажилтны	



**“ПЕТРОЛАЙН” ХХК-Н ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	Ажлын байранд агааржуулалтыг сайжруулах механик сэлгэлт хийж байх,	орчин үеийн дэвшилтэт агааржуулалтын системийг сонгон авах	ТОГТМОЛ	Үйл ажиллагааны хүрээнд		2024 он	сонсгол хамгаалахад тавих ерөнхий шаардлага
Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө							
Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, ахуйн хог хаягдлаар хөрс бохирдох	Хөрсний бохирдлоос хамгаалах зорилгоор бүх ажилчдад техникийн болон ахуйн хэрэглээний аюултай материал (шатамхай хий, шатах, тослох материал)-тай харьцах асуудлаар цогц сургалт, зааварчилгаа явуулах	Машин техник	ТОГТМОЛ	Үйл ажиллагааны хүрээнд		2024 он	MNS3297-1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм”
	Хатуу хог хаягдлыг цуглуулж, зохих журмын дагуу зайлуулж байх	Үүсэх хог хаягдал	Тухай бүрд	Үйл ажиллагааны хүрээнд		2024 он	UCS 1701A:2022 “Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент” хотын стандарт
	Зориулалтын хог хаях цэгээс бусад газар хог хаягдал хаяхгүй байх, хог хаягдлыг ангилан ялгах арга хэмжээг хэвшүүлэх талаар ажилчдад заавар зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулах, самбар пайз байрлуулах	Төслийн талбайд	Тухай бүрд			2024 он	
Хөрсний үржил шимт давхаргыг хуулах хөрсний үржил шимт байдал алдагдах	“Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт MNS 5916:2008”-д заасны дагуу хөрсний ялзмагт давхаргаас хамаарч хөрсийг хуулж, тусад нь хадгалах	Хөрсөн бүрхэвч	Тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд			MNS 5916:2008
Асгаралтын иж бүрдэл ашиглах	Шатах тослох материал асгарсан тохиолдолд асгаралтын иж бүрдэл байршуулах	Замын хэсэгт ойр байрлуулах	2ш	250.000	500.000	2024 он	MNS ISO22320:2020



**“ПЕТРОЛАЙН” ХХК-Н ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Авто машины хөдөлгөөнөөс хөрсөн бүрхэвч эвдрэлд өртөх	Гадаа машины зогсоолт нэмэлтээр байгуулах	Төслийн талбайн хэсэгт	төг	Дотоод зардалд тусгах		
Тээвэрлэлтээс хөрс, газрын гадарга эвдрэх	Хөрсний элэгдэл эвдрэл үүсэхээс сэргийлэх зорилгоор барилгын үйл ажиллагаа, тоног төхөөрөмж тээвэрлэлтээс өмнө тээвэрлэлт хийх замын маршрут, тогтсон маршрутын дагуу явуулах ба авто замын засвар үйлчилгээг тогтмолжуулах.	Олон салаа зам гаргах, замгүй газраар тээврийн хэрэгсэл зорчихыг хориглох	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд		MNS 4597:2003 Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага
	Зам болон хөрс газрын хэвлийг эвдрэлд оруулахгүй байх бүх талын арга хэмжээг авах, үерийн хамгаалалтын далан, суваг шуудуу байгуулах					БОАЖ-ын сайд, ЭМ-ын сайдын хамтарсан тушаал-А/82/128 тоот журам
Тээвэрлэх, ачих буулгах явцад сав, баглаа боодол нь задрах, асгарах	Түргэн ууршигтай органик шингэн бодисууд асгарсан тохиолдолд хөрснөөс түргэн ууршиж зайлуулагдана. Агаарт гидроксидийн радикалыг үүсгэн задарна.	Хөрсөн бүрхэвч	Тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд		
<b>Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ</b>						
Бохирдлын эх үүсвэр шатах тослох материал, ахуйн бохир ус болно. гадаргын болон газрын доорх усыг шууд, шууд бусаар бохирдуулах	Тослох шатах материалыг хадгалах, тээвэрлэх, ашиглах аюулгүй ажиллагааны журам боловсруулж хэрэгжүүлэх.	Төслийн хэрэгжиж буй замын хэсэгт	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд		MNS 4586: 1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
	Борооны ус хуримтлуулан дахин ашиглах зөвлөмж	Ус хэмнэх	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд		“Усны тухай хууль” Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль





**“ПЕТРОЛАЙН” ХХК-Н ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Гадаргын болон гүний усны эх үүсвэр бохирдох	Төлсийн талбайд нефтийн бүтээгдэхүүний бохирдол үүсгэхээс зайлсхийх	Төлсийн талбай	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд			Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам
	Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөж ажиллах	Төлсийн талбай	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд			
	Газрыг тэгшилж, хур борооны ус, чийг шүүрч нэвчихээс сэргийлж гадаргын урсац зайлуулах суваг татах	Төлсийн талбай	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд			
<b>Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө</b>							
Зам ашиглалт, тоосжилтоос шалтгаалан замын дагуух ургамал нөмрөг доройтох	Орчны ургамлан бүрхэвч устах, талхлагдах, олон салаа зам гарахаас сэргийлэх, чөлөөт зорилтыг хязгаарлах арга хэмжээ авах	Төлсийн талбай доторх	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгасан болно.			2024 он	Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. - MNS 5918:2008; Цэцэрлэг зүлэг ногоон байгууламж
	Замын хажуу хэсгийн ургамлыг аль болох сүйтгэхгүй байх. Машин техник тоног төхөөрөмж зөвхөн төлөвлөсөн замын дагуу явах бүтээгдэхүүн ачиж, буулгах явцад хөрс, ургамлан бүрхэвч дээр дизель түлш асгахгүй байх	Төлсийн талбай	Үйл ажиллагааны хүрээнд			2024 он	
<b>Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ</b>							
Хөрсний бичил амьтад устаж дайжих	Хөрсөн орчны бохирдол ихэссэнээр хөрсний бичил биетнүүд багасах ба үүнээс сэргийлж ариутгал хийх	Төлсийн талбай	2ш	250.000	500.000	2024 он	MNS ISO22320:2020
	Агуулах дотор хортон шавж орох, мэрэгчид үүрлэн үүрээ засахаас сэргийлж ариутгах	Төлсийн талбай	Үйл ажиллагааны хүрээнд			2024 он	MNS 5161-2 - 2002
							<b>Нийт дүн: 1.600.000</b>



## 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6.Төслийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
“Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай” хуулийн 7.2.4-д аж ахуйн нэгж байгууллага нь өөрийн эзэмшлийн газрын 10-аас доошгүй хувьд мод, зүлэг тарина гэж заасан байдаг.	<i>шар хуайс, монос, голт бор, долоогоно, чацаргана г.м тарьж ургуулах</i>	Нийслэлийн байгаль орчны газартай хамтран ажиллах	ш	280	10000	2.800.000	2024 он	Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. - MNS 5918:2008;
Тээвэрлэлт хийх зардал	Мод тээвэрлэх зардал	Төслийн талбайд буулгах	-	1	75.000	75.000	2024 он	
<b>Нийт дүн: 2.875.000</b>								

## 7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл	Ажлын идэвхтэй талбайг тойруулан хангалттай/зохистой гэрэлтүүлж, гэрэл цацруулагч саад (боломжтой бол, түр хашаа барих) тавих	Төслийн талбайн эрүүл ахуйн хамгаалалтын бүс	Дотоод зардалаар төлөвлөх			2024 он	MNS 4990: 2015 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага”;
	Гал гарах зэрэг онцгой нөхцөлд хариу ажиллах бэлэн байдал (журам мөрдөх, ажилчдыг сургах, тоног төхөөрөмж, хэрэгсэл, хангамж ),	Төслийн талбайн ажилчдад	Үйл ажиллагааны хүрээнд			2024 он	MNS ISO 13688:2000, “ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага”;



**“ПЕТРОЛАЙН” ХХК-Н ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	Төслийн тухай мэдээллийн самбар, ажил эхлэх, дуусах хугацаа, Гүйцэтгэгчийн нэр, холбоо барих хаяг, талбайн удирдах ажилтан, ачааны машинуудын явах зам, төслийн зохион байгуулалт зэргийг мэдээлнэ.	Төслийн талбайн ажилчдад хэсэгт	3	640.000	640.000	2024 он	
Үйл ажиллагааны явцад ажиллагсад осол, аварга өртөж болзошгүй	Ажилчид ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл, аюулгүй байдлын дүрмийг хатуу мөрдөх талаар танилцуулна.	Бүх ажилчдад	Үйл ажиллагааны хүрээнд			2024 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Сургалтын хөтөлбөр
	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм журмуудыг бүрэн боловсруулж мөрдүүлэх, курс, сургалтын болон зааварчилгаа өгөх ажил зохион байгуулах	Бүх ажилчдад	Үйл ажиллагааны хүрээнд			2024 он	
	Осол эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авч ослын үед ажиллах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангах	Бүх ажилчдад	Үйл ажиллагааны хүрээнд			2024 он	
Галын аюулгүй байдлыг хангаагүйгээс гал түймрийн осол аварга өртөх	Гал түймрээс хамгаалах багаж хэрэгслийг бүрдүүлж бэлэн байдлыг хангах	агуулахад	1 ш	500,000	500,000	2024 он	Гамшгаас хамгаалах тухай хууль, /шинэчилсэн найруулга/ 2017 он; MNS 4244:1994 “Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага”
	Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл болох лоом, хүрз, сүх, хөрөө, хувин, хоолой, багор дэгээ, жоотуу, тармуур, хөөс, хорны суурь, тэмдэг тэмдэглээ, сарай, элсний хайрцаг, шланг зэргийг бэлэн байлгах,	Бүх ажилчдад	Үйл ажиллагааны хүрээнд			2024 он	
							<b>Нийт дүн: 1,140,000</b>

**8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

*Хүснэгт 8. Түүх соёл өвийг хамгаалах төлөвлөгөө*

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
--------------------------------	-----------------------	---------------------------	------------	---------------------	------------------	-----------------------------	---------------------------------



**“ПЕТРОЛАЙН” ХХК-Н ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн үйл ажиллагаагаар түүх соёлын өвд үзүүлэх шууд сөрөг нөлөө байхгүй ч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай.	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хууль	2024 он	Бүтээн байгуулалтын үйл ажиллагааны явцад	Тухайн үед нь шийдвэрлэх	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
---	--	---------	---	--------------------------	------------------------------------

## 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны БОМТ-ний хүрээнд төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал, хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэглээний норм, гэх зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэн дараах байдлаар тооцлоо.

*Хүснэгт 9. Төслийн хог хаягдлын төлөвлөгөө*

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Хог хаягдлын менежментийг зохистой төлөвлөн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх буюу 3R зарчмыг баримтлан ажиллах	Төслийн талбай	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд			2024 он	MNS3297-1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм”  Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7, 8.1.7а, 8.1.7.б, 8.1.7.г, 8.1.9, 8.1.9.а-д
	Хатуу шингэн хог хаягдлыг графикийн дагуу тогтоосон зөвшөөрөл бүхий нэгдсэн хогийн цэг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж зайлуулах	Төслийн талбай	төг	40.000	12	480.000	2024 он	
	Нэмэлтээр аюултай хог хаягдал болон энгийн хог хаягдлын сав байршуулах	Төслийн талбай	тогтмол	500.000	4	2.000.000	2024 он	
	Талбайн цэвэрлэгээ хийх ба хог хаягдлыг зайлуулах явцад гүйцэтгэгч нь нийтийн болон хувийн өмчийг гэмтээхгүй ба замын хөдөлгөөнд саад учруулахгүй байх	Төслийн талбай	тогтмол	Үйл ажиллагаа төслийн хүрээнд			2024 он	
	Бүх нийтийн их цэвэрлэгээг тогтмол зохион байгуулах	Төслийн талбай	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд			2024 он	
<b>Нийт дүн: 2.480.000</b>								



## 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь “Газрын тосны бүтээгдэхүүний агуулах” төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлох, болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой. Бид 2024 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа болон давтамжийг тусгалаа.

Хүснэгт 10. Төслийн орчны хяналт шинжилгээ хийх төлөвлөгөө

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал, төг	Тайлбар	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хөрсний өнгөн болон дээд үе давхаргын элсжилт, чулуужилт, тоосжилт зэрэг морфологи тогтцын өөрчлөлтийг хянах	Төслийн талбайд 1 байршилд	Төслийн талбайд	1 удаа	90.000	90.000	Үйл ажиллагаа жигдэрсэн үед хийлгэх	2024 он	MNS 5850:2019,
Газрын тосны бүтээгдэхүүний агуулахаас дээж авах	Автобензин Дизелийн түлш	Төслийн талбайд	Жилд 1 удаа 10 Сард	295.000	295.000	Үйл ажиллагаа жигдэрсэн үед хийлгэх	2024 он	ISO/IEC 17025:2017 (MNS ISO/IEC 17025:2018) стандартын шаардлага
<b>Нийт дүн: 385.000</b>								

## 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 11. Төслийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		2024 он				
		Сар	Сар	Сар		



**“ПЕТРОЛАЙН” ХХК-Н ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Ажилчдад аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол зохион байгуулж байх;	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	Улирал бүр	" Петролайн" ХХК Захирал	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, Үйлдвэрлэлийн эрүүл ахуй” MNS ISO 13688: 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын тусгай хувцас- Ерөнхий шаардлага
Ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах;	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	Жилд 1 удаа	" Петролайн" ХХК Захирал	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын тусгай хувцас- Ерөнхий шаардлага
Тухайн жилийн БОМТөлөвлөгөөг батлагдсан журмын дагуу жил бүр боловсруулан БОАЖГ-аар батлуулах;	Дотоод төлөвлөлтөөр	2024 он	" Петролайн" ХХК Захирал	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Мэргэжлийн байгууллагатай хамтран хог хаягдлын талаар жилд 1 удаа сургалт зохиох	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	2024 он	" Петролайн" ХХК Захирал	Хог хаягдлын тухай хууль

**12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

*Хүснэгт 12. Төслийн нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө*

БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
Газрын тосны бүтээгдэхүүний агуулах төслийн БОМТ БОХ-ыг таниулах, мэдээлэх, тус багийн оршин суугчдад таниулах	Цаасан хэлбэрээр	Төлөвлөгөөт Ажлын тайлан, Биелэлтийн үр дүн, Дараа жилийн БОМТ	Жил бүрийн 10 дугаар сард	Дотоод төлөвлөлтөөр	" Петролайн" ХХК Захирал	" Петролайн" ХХК
Газрын тосны бүтээгдэхүүний агуулах төслийн харьяаллын	Мэдээллийн илтгэл, хэвлэмэл танилцуулга	Төлөвлөгөөт Ажлын тайлан, Биелэлтийн үр дүн,	Жил бүрийн 10 сарын 15-ны дотор	Дотоод төлөвлөлтөөр	"Петролайн" ХХК Захирал	Хорооны ИНХ-н танхимд



**“ПЕТРОЛАЙН” ХХК-Н ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

сумын ИНХ,		Дараа жилийн БОМТ				
------------	--	----------------------	--	--	--	--